

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2019 ОНЫ НАЙМДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 08 дугаар сарын 26

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2019 оны 07 дугаар сарын 26-ний өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 25-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-ын гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Бичигт боомтууд хэлэлцээр ёсоор хуваарийн дагуу ажиллалаа. Тус сард ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн урсгал, сүлжээний инженер Ө.Хосбаяр, жижүүр Ц.Хүрэлдорж, жолооч Б.Ренчиндорж нар 2019 оны ээлжийн амралтаа биеэр эдлээд ажилдаа орсон бол сүлжээний инженер Б.Бадамринчин жирэмсний амралт эдэлж ахлах нягтлангийн оронд түр ажиллаж байсан Н.Хулан ажлаас чөлөөлөгдсөн. Мөн энэ хугацаанд мэргэжилтэн Д.Оюунчимэг, Х.Тайванбаатар нар байгууллагын даргын тушаалаар ажлын 7-10 хоногийн чөлөө эдэлсэн болно.

Нэг. Захиргаа, удирдлага

Байгууллагын даргын 2019 оны “Д.Оюунчимэгт чөлөө олгох тухай” Б/192, “Төрийн захиргааны зарим албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн шатлалыг шинэчлэн тогтоох тухай” Б/196, “Н.Хуланг ажлаас чөлөөлөх тухай” Б/197, “Х.Тайванбаатарт чөлөө олгох тухай” Б/195 дугаар тушаалуудыг хүлээн авч хэрэгжүүлсэн.

Газрын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагч нарын нийгмийн баталгааг хангах үүднээс Зүүн бүс дэх газрын даргын А/07 “Албадан гаргах, хуяглан хүргэх зардал гаргах тухай”, Б/10 дугаар “Төрийн үйлчилгээний албан хаагчдад наймдугаар сард ур чадварын нэмэгдэл олгох тухай”, Б/10 дугаар “Д.Оюунчимэгт мөнгөн тусламж олгох тухай” тушаалыг тус тус батлан хэрэгжүүлэн ажилласан.

Удирдлагаас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст бүсийн газрын 07 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, байгууллагын даргын 2017, 2018, 2019 оны албан даалгавруудын биелэлт, 08 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө зэргийг тус тус хүргүүлсэн.

Уулзалт, зөвлөгөөн: Дарга Б.Тамир Дорнод аймгийн Засаг даргын удирдамжаар баталсан Түүхт Халх голын ялалтын 80 жилийн ойн баярыг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хуралд оролцсон.

Дорнод аймгийн хэмжээнд энэ оны 07 дугаар сарын 27, 28-ны өдөр зохион байгуулагдсан “Зүүн бүсийн их хурд баяр наадам”-ын арга хэмжээний “Шагайн харваа”-ны тэмцээн зохион байгуулах хорооны даргаар бүсийн газрын дарга

Б.Тамир томилогдон ажилласан бөгөөд хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, жолооч Т.Алтанпүрэв нар аймгийн Шагайн харвааны холбооны тэргүүн, гишүүдийн хамт тэмцээнийг амжилттай зохион байгуулан, дүн мэдээ тайланг Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар хүргүүлсэн.

Аймгийн засаг даргад нутгийн иргэдийн төлөөллөөс Дорнод Аймгийн Матад сумд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй “Петроматад” ХХК-ийн үйл ажиллагааны талаар ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу аймгийн хууль хяналтын байгууллагуудын удирдлагуудын хамт хуралдан, мөн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хамтран зохион байгуулсан.

Газрын дарга даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна. Байгууллагын даргын 2019 оны А/75, А/94, 2018 оны А/144 тушаалын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллах, хилийн боомтоор зорчигч гадаадын иргэний хяналтыг сайжруулах үүднээс албан хаагчдад 12/90 тоот албан бичгээр тодорхой үүрэг чиглэл өгч ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг 08 дугаар сарын 23-ний өдрийн 16-18 цагийн хооронд Дорнод аймгийн ЗДТГ-т зохион байгуулагдсан “Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдэвт уулзалтад ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн-Урсгал, мэргэжилтэн А.Нэмэхбаяр нар оролцсон.

Нийгмийн баталгааг хангах талаар: Албаны байрны хашаанд зэрлэг ургамал ургаж өнгө үзэмж дарсан байсныг байгууллагын жижүүр, үйлчлэгч, жолооч нар зулгааж цэвэрлэсэн.

Хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын ая тух, амьдрах нөхцөлийг сайжруулах үүднээс ОХУ-тай хил залгаа Ульхан боомтын амралтын байрны хана, шал, таазыг дулаалж, цахилгааны монтажийг шинээр хийн, өнгө будгийг сэргээж засварласан. Энэ тухай танилцуулгыг байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.

Бичиг хэргийн эргэлтийн талаар:

Ирсэн бичиг: Байгууллагын төвөөс 2, бусад байгууллагаас 6 нийт 8 албан бичиг ирж, үүнээс хариутай 2 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн

Явсан бичиг: Дотоод ажлын зохион байгуулалттай холбоотойгоор албан хаагчдад 1 албан үүрэг, төвийн нэгжүүдэд 1, байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор бусад байгууллагад 9 нийт 11 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажилласан байна.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас хувийн чөлөө хүссэн 4 өргөдөл, хүсэлт хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн.

Тус сард Зүүн бүс дэх газрын ББНШК /Баримт бичиг нягтлан шалгах комисс/ хуралдаж тус Бүсийн газрын 2019 онд хөтлөх хэргийн жагсаалтыг нэгж тус бүрээс гаргуулан авч нэгтгэн байгууллагын удирдлагаар батлуулахад бэлэн болгосон. Мөн энэ хуралдаанаар 2018 онд хөтөлж бүрдүүлсэн Байнга хадгалах 18, 70 жил хадгалах 3, түр хадгалах 132 нийт 154 нэгжийг архивд хүлээн авахаар хуралдан шийдвэрлэсэн. 90*120 харьцаатай самбар хийлгэж архивын өрөөнд байрлуулсан.

Санхүүгийн талаар: 2019 оны 8 дугаар сард 46,626,000.00 төгрөгийн санхүүжилтийг авснаас 34,766,473.59 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2019 оны 07 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн 318,162,900.00 төгрөгийн санхүүжилт, 270,981,167.14 төгрөгийн гүйцэтгэлтэй, 47,181,732.86 төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 07 дугаар сарын тайлангаар хүү, торгуулийн орлогод 770,000.00 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж орлогод 10,972,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын 07 дугаар сарын тайлангаар нь нийт 28 албан хаагчдын 26,506,255.39 цалин, ногдол 6,201,236.95 төгрөг гарсныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтад 2019 оны 07 дугаар сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

Эд, хөрөнгө, хангалтын талаар: Газрын үйл ажиллагааны урсгал зардал, төлбөрийг 07 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон харилцагч байгууллага болох “Дорнод Нийтийн Аж Ахуй” ХХК, “ДБЭХС” ТӨХК, “Цахилгаан холбоо” ХК, “Монгол шуудан” ХК, “НИК” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-тай тооцоо нийлүүлсэн. Мөн автомашины зам/км, шатахууны тооцоо, бараа материалын тайланг гарган ахлах нягтлан бодогчид тайлагнасан.

Бүсийн газрын “Техникийн комисс” 5-н удаа хуралдаж бүсийн төвд ашиглаж байгаа 8222ДОР улсын дугаартай “Ниссан Патрол” автомашины турбо, өндөр даралтын насос эвдэрсэн талаар хэлэлцэж автомашины аюулгүй бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах үүрэгтэй учраас сэлбэгийг худалдан авч тавихаар шийдвэрлэсэн.

Хангалт үйлчилгээний чиглэлээр: Ульхан боомтын амьдрах байр нь ашиглалтад ороод олон жил болсон, урсгал засвар хийгдээгүй удсан тул шал, хананаасаа дулаанаа алддаг учир албан хаагч нарынхаа тав тух, аюулгүй байдлыг хангах үүднээс урсгал засварыг 21 нэр төрлийн 59 ширхэг 2,126,650 төгрөгийн үнэ бүхий материалын худалдан авалт хийж шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан. Аж ахуй хангамжийн чиглэлээр бүсийн төвд архивын мэдээллийн самбарыг захиалгын дагуу хийлгэж хүлээлгэн өгсөн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: Хил хамгаалах байгууллагаас сүлжээнд “managed switch” төхөөрөмж шинээр суурилуулсантай холбоотойгоор тул Ульхан боомтод шинээр 110 метр газар гадна сүлжээний монтаж татаж, өргөтгөл хийсэн.

Төвөөс хяналт шалгалтад зориулан “Phantom 4 pro +” маркийн иж бүрэн дроныг өгснийг хүлээн авч гарын авлага, холбогдох эд зүйл, удирдах заавартай нь танилцан албан хэрэгцээндээ ашиглаж байна.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа хяналтын улсын байцаагч Г.Хосбаатар, мэргэжилтэн А.Нэмэхбаяр нарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг

бүртгэн авч, мэдээллийн технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн.

Дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа компьютеруудад Eset endpoint security антивирусны програмын лиценз сунгах ажил хийгдэж байна.

Монгол Улсад анх удаа хөдөлмөр эрхлэхээр ирсэн нийт 6 гадаадын иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан.

Ульхан боомтын “Дэлл T1700” маркийн компьютер дотоод сүлжээнд холбогдохгүй болсон тул нөөцөд байсан “Дэлл 3060” маркийн 1 ширхэг компьютерыг форматлан, хэрэглээний програмуудыг суулган мэргэжилтэн Д.Оюунчимэгт хүлээлгэн өгч, дотоод сүлжээнд холбож хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 6 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар нийт 11 орны / АНУ, БНХАУ, ХонгКонг, Япон, ОХУ, БНБеларусь, БНИталь улс, БНСУ, Кыргызийн БНУлс, Недарландын вант улс, ХБНГУ / 6652 гадаадын иргэн улсын хилээр нэвтэрснээс орох чиглэлд 9 орны /БНХАУ, ХонгКонг, Япон, АНУ, БНБеларусь улс, БНСУ, ОХУ, ХБНГУ, Недарландын вант улс / 3622 гадаадын иргэн, гарах чиглэлд 8 орны / БНХАУ, ОХУ, ХБНГУ, АНУ, ХонгКонг, БНБеларусь, Кыргызийн БНУлс, Япон / 3030 гадаадын иргэн нэвтэрснээс БНХАУ-ын 95, Япон улсын 1 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуу виз олгосон. Үүнд:

- **“HG”** ангиллын визийг **77** иргэнд олгосон. Үүнээс:
 - “гарах-орох” нэг удаагийн зориулалттай виз **-59**
 - Визийн шилжүүлэг- **18**
- **“H”** ангиллын визийг **1** иргэнд олгосон. Үүнээс:
 - Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз **-1**
 - Визийн шилжүүлэг- **1**
- **“J”** ангиллын визийг **13** иргэнд олгосон. Үүнээс:
 - Нэг удаагийн “орох” зориулалтын виз **-13** /04/19-4479, 04/19-5820, 04/19-5895, 04/19-6007 тоот дугаарын зөвшөөрлийн дагуу/
- **“TS”** ангиллын визийг **2** иргэнд олгосон. Үүнээс:
 - Хоёр удаагийн “гарах-орох” зориулалтын виз **-2**
- **“T”** ангиллын визийг **1** иргэнд олгосон. Үүнээс:
 - Визийн шилжүүлэг- **1**-ийг тус тус олгосон.

“Адуунчулуун” ХХК-ний олон удаагийн “В” ангиллын визийн зөвшөөрлийг БНХАУ-ын 1 иргэнд хүссэн тухай албан хүсэлтийг хүлээн авч бүсийн газрын даргад танилцуулан виз, зөвшөөрөл, харьяатын газарт илтгэх хуудсаар танилцуулан хүргүүлсэн.

Хүчингүй болгосон виз: Хавирга боомтод БНХАУ-ын 8 иргэнд Бээжин хотод суугаа дипломат төлөөлөгчийн газраас олгосон “HG” ангиллын нэг удаагийн орох,

визийн байх хугацааг алдаатай олгогдсон визийг Монгол Улсын виз олгох журмын 5.2, 5.2.4-д заасныг үндэслэн хүчингүй болгож шинээр виз олгосон.

- Бичигт боомтод БНХАУ-ын 1 иргэнд Эрээн суугаа дипломат төлөөлөгчийн газраас олгосон “Т” ангиллын олон удаагийн орох зориулалтын визийг уригчийн мэдээлэл алдаатай олгогдсон визийг Монгол Улсын виз олгох журмын 5.2, 5.2.4-д заасныг үндэслэн хүчингүй болгож шинээр виз олгов.

Алдаатай визийн бүртгэл: Хавирга боомтод БНХАУ-ын 8 иргэнд Бээжин Элчин Сайдын Яамнаас олгосон “НГ” ангиллын нэг удаагийн орох, визийн алдаатай олгогдсон байсныг бүртгэлд авч 8 иргэнд шинээр виз шилжүүлэг хийсэн.

- Бичигт боомтод БНХАУ-ын 1 иргэнд Эрээн суугаа дипломат төлөөлөгчийн газраас олгосон “Т” ангиллын олон удаагийн орох зориулалтын визийг уригчийн мэдээлэл алдаатай олгогдсон визийг бүртгэлд авч шинээр визийн шилжүүлэг хийсэн.

Түр ирэгчийн бүртгэл, хасалт: Уригч иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу БНХАУ-ын “НГ” ангиллын визтэй 9 /Ган хийц ХХК-ний албан хүсэлттэй 8, Эрдэнэмөнх ХХК-ны 1 иргэн/, “Н” ангиллын визтэй 2 иргэн, нас барсан 1 иргэн, визгүй 8 /АНУ-ын 8 иргэн/ БНХАУ-ын нийт 20 иргэнийг түр ирэгчээр бүртгэсэн.

АНУ-ын 8 иргэн, БНХАУ-ын 3 иргэн, нас барсан БНХАУ-ын 1, нийт 12 иргэнд тус тус хасалт хийсэн.

ХОНДЗҮ-ээр хил нэвтэрсэн БНХАУ-ын 157 иргэнийг бүртгэж, 179 иргэнийг хассан.

Зөвлөгөө мэдээлэл: Сүхбаатар аймагт БНХАУ-ын 19, АНУ-ын 8 иргэнд түр ирэгчийн бүртгэл, виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар, Хавирга боомтод БНХАУ-ын 56 иргэнд виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар, Бичигт боомтод БНХАУ-ын 20 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн талаар, Баянхошуу боомтод БНХАУ-ын 2 иргэн, 1 аж ахуйн нэгжид виз, визийн ангиллын талаар зөвлөгөө өгсөн.

Бүсийн төвд олон удаагийн визийн хүсэлт гаргасан БНХАУ-ын 1 иргэнтэй, хилийн боомтуудад БНХАУ-ын 16 иргэний виз Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн эсэх талаар ярилцлага хийн тэмдэглэл хөтөлсөн.

Сүлжээний хяналт: ОХУ-д гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-д гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Бичигт боомтуудад хилээр зорчиж буй ОХУ-ын 322, БНХАУ-ын 5504, АНУ-ын 1, БНБеларусь улсын 2, БНСУ-ын 1, ХБНГУ-ын 4, ХонгКонг улсын 4, Япон улсын 6 Бүсийн төвд 11 нийт 5855 гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнд шалган нэвтрүүлсэн.

Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газар нь тайлангийн хугацаанд Бүсийн газрын даргын баталсан №12/05-201914 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Хэнтий аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар 1, Дорнод аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын даргын удирдамжаар 1, Дорнод аймгийн Тагнуулын газрын мэдээллийн дагуу 1, нийт 4 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалт: Төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтад нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагын, БНХАУ-ын 150 иргэн хамрагдсан. Шалгалтын явцад

БНХАУ-ын 15 иргэнийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн үйлдэлд торгуулийн арга хэмжээ оногдуулах, Монгол Улсаас албадан гаргах дүгнэлтийг хяналт шалгалтын газарт хүргүүлж, шалгалтын ажиллагаа үргэлжилж байна. БНХАУ-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дэх заалтыг үндэслэн 100,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулсан.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар: Хэнтий аймгийн Засаг даргын баталсан 1 удаагийн удирдамжийн дагуух шалгалтад нийт 6 аж ахуйн нэгжийн, БНХАУ-ын 30 гадаадын иргэн хамрагдсан. Шалгалтаар БНХАУ-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн 3.3 дэх заалтыг үндэслэн 260,0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсаас албадан гаргасан.

Дорнод аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын даргын удирдамжаар хийгдсэн шалгалтад 1 аж ахуй нэгжийн, БНХАУ-ын 10 иргэн, Тагнуулын мэдээллийн дагуу хийгдсэн хяналт шалгалтад 1 аж ахуй нэгж., БНХАУ-ын 8 иргэн хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Зөрчил шийдвэрлэсэн талаар: Бүсийн хэмжээнд 2 зөрчил илрүүлж, 360,000,00 /гурван зуун жаран мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээг ногдуулсан.

Хил дээрээс буцаагдсан иргэдийн талаар: Хавирга боомтод Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3 иргэн / Засгийн газрын 145 дугаар тогтоолын 3,9, ГИЭЗБТХ-ийн 22.1.1, 22.1.6 дахь заалтыг үндэслэн/, Бичигт боомт БНХАУ-ын 4 иргэн /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн/, Эрээнцав боомт ОХУ-ын 2 иргэн /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн/, Ульхан боомт ОХУ-ын 1 иргэн /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн/ нийт 10 иргэнийг орох чиглэлд хилээр нэвтрүүлэлгүй буцаасан.

Албан шаардлага хүргүүлж ажилласан талаар: Хэнтий аймгийн “Бор-Өндөр” сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Түшиг Интернэшнль” ХХК-д хяналтын улсын байцаагчийн 12/074-201907 тоот “Албан шаардлага”-ыг хүргүүлсэн.

Албадан гаргалтын талаар: Тайлангийн хугацаанд хяналт шалгалтын явцад БНХАУ-ын 1 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.7 дахь хэсэг, 2010 оны Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7 дахь заалтад заасны дагуу 3 жилийн хугацаагаар Монгол Улсад дахин орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргасан.

Байгууллагын даргын №04 албан даалгаврын хүрээнд:

Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан эрх зүйн хэлбэрийг зааврын дагуу үйлдэж зөрчил тус бүрд дугаарлалтыг өгч ажилласан.

Сүхбаатар аймагт 2 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж харьяа Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хяналтад оруулах ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн объектын судалгааг аж ахуй нэгж, оршин сууж буй хэлбэрээр тус бүр нарийвчлан гаргаж шинэчилсэн судалгааны ажлыг хийж дуусгаж, нэмэлт баяжилт хийж явж байна

Байгууллагын даргын 2019 оны 03 тоот албан даалгаврын хүрээнд:

1. Тайлангийн хугацаанд 2 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж нийт 360.000.0 /гурван зуун жаран мянга/-н төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, зөрчлийг шийдвэрлэсэн байна.

2. Хасалтын хугацаанд Монгол Улсаас гараагүй гадаадын иргэн байхгүй .

3. Бүсийн хэмжээнд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Монгол Туйвр” ХХК-ийн оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн гадаадын 7 иргэний зөрчил шийдвэрлэлтийн шатанд явагдаж байна.

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР